



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/146

Улаанбаатар хот

Ээлжийн амралтын хуваарь батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5.1, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйл, 110 дугаар зүйл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаал, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны А/47 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Ажилтан, албан хаагчдын 2022 оны 07 дугаар сарын ээлжийн амралтын хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Ээлжийн амралтаа эдэлж буй албан хаагчдын ажлыг цалгардуулахгүй, тухай бүр зохицуулалт хийж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Коронавирус (Ковид-19)-ын цар тахлын шар түвшинд байгаа тул халдвараас өөрийгөө болон бусдыг хамгаалах үүргээ ухамсарлан дагаж мөрдөх дүрэм журмыг сайтар сахих, ажлын зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд гар утас унтраахгүй, дуудсан цагт тайлбар өгөлгүй бэлэн байхыг нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

4.Албан хаагчдын ээлжийн амралтын олговрыг зохих журмын дагуу тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Дугармаа)-д зөвшөөрсүгэй.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар (Л.Батзориг)-д даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

142022 02233